# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 22 он 12 сарын 21 өдөр

Дугаар 3Г-1/166

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР
ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000224001010

# МОНГОЛ УЛС
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20.22.. он 12... дугаар
сарын 16...-ны өдөр

Дугаар ХЭТ/3054

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 40... хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН
# ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
# ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 61 дүгээр тэмдэглэлд:

"YI.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл:info@mof.gov.mn
Вэбсайт:www.mof.gov.mn

2022.12.14 № 01/8766

танай ______ -ны № ______ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (АДБХОБ) хамтран хэрэгжүүлэх "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрөв.

Хавсралт: 13 хуудас.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761001662

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.12.16 № 1/6360
танай 2022.12.14-ны № 01/8467-т

САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Х.НЯМБААТАР

151605968
А5 Файл.2022

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27,
Цахим шуудан: info@mfa.gov.mn,
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2022. 12. 16 № 05/6606

танай ________-ны №________-т

САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийн дагуу Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хооронд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн зээлийн хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.

Б.БАТЦЭЦЭГ

115223128

| | | | |
|---|---|---|---|
| БАТЛАВ<br>САНГИЙН САЙД | БАТЛАВ<br>ЭДИЙН ЗАСАГ,<br>ХӨГЖЛИЙН САЙД | БАТЛАВ<br>ГАДААД<br>ХАРИЛЦААНЫ<br>САЙД | БАТЛАВ<br>ХУУЛЬ ЗҮЙ,<br>ДОТООД ХЭРГИЙН<br>САЙД |
| Б.ЖАВХЛАН | Ч.ХҮРЭЛБААТАР | Б.БАТЦЭЦЭГ | Х.НЯМБААТАР |

# МОНГОЛ УЛС, АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР (МӨЧЛӨГ СӨРСӨН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР)-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

## Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэл, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан, Төсвийн байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдааны санал дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 201 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-т Сангийн сайд Б.Жавхлан 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр гарын үсэг зурсан.

Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр) нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад заасан гадаад улс, олон улсын байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн тухай олон улсын гэрээ болох тул Улсын Их Хурлаар заавал соёрхон батлуулах шаардлагатай.

## Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй байх бөгөөд тус зүйлд Монгол Улс, Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк хооронд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүй үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Монгол Улс, Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк хооронд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг соёрхон батлах тухай хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн аливаа сөрөг үр дагавар байхгүй бөгөөд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр эдийн засагт учраад буй сөрөг шокийн үед нийт хүн ам, тэр дундаа эмзэг, ядуу иргэдийн өртөмтгий байдал, Монгол Улсын эдийн засагт үүсээд буй инфляц, төлбөрийн тэнцлийн сөрөг нөлөөллийг бууруулахад дэмжлэг үзүүлэх бөгөөд цаашид тус хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн хөрөнгө нь гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх болон төсвийн тусгай шаардлагыг хангахад чухал ач холбогдолтой болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай, Хууль тогтоомжийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль байхгүй болно.

## ТАНИЛЦУУЛГА

*Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг*
*дэмжих хөтөлбөрийн талаар*

### А. Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хоорондын хамтын ажиллагаа

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк /АДБХОБ/-ны гишүүнээр Монгол Улс 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр элссэн байдаг. Үүнээс хойш, "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах хөтөлбөр"-ийн хүрээнд 2020 оны 09 дүгээр сард 100.0 сая ам.долларын санхүүжилттэй төсвийн дэмжлэгийн зээл болон 2021 оны 07 дугаар сард 21.0 сая ам.долларын санхүүжилттэй "КОВИД-19 вакцинжуулалтын арга хэмжээ төсөл"-ийн зээлийн хөрөнгийг тус тус Монгол Улсын Засгийн газарт олгож эдгээр хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

### Б. "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"

"Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд АДБХОБ-ны зүгээс 100.0 сая ам.доллартой тэнцэх зээлийн хөрөнгийг хамтын санхүүжилт[1] хэлбэрээр олгохоор зээлийн хэлэлцээрийг 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр хийгээд байна.

БНХАУ-ын баримталж буй "Тэг-КОВИД" бодлогын улмаас тогтоосон хилийн хязгаарлалт болон Оросын Холбооны Улс болон Украин улсуудын хямралт нөхцөл байдлаас шалтгаалан хүнс, эрчим хүчний үнэ огцом нэмэгдэж, нийлүүлэлтийн сүлжээний тасалдлыг бий болгосон. Түүнчлэн инфляцын түвшин өсөж, гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн хямрал улс орнуудын эдийн засагт хүндрэл учруулж байна.

Сүүлийн 40 жилд тохиолдоогүй өндөр инфляцын түвшнийг тогтворжуулахаар улс орнууд Төв банкны бодлогын хүүгээ чангаруулж байгаа ба АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүг 2022 оны эхний 9 сард 5 удаа эрс нэмэгдүүлсэн нь ам.долларын ханшийг голлох валютуудын эсрэг 15 орчим хувиар өсгөж, хөгжиж буй орнуудад өрийн болон валютын ханшийн дарамтыг нэмэгдүүллээ.

Дэлхийн эдийн засагт үүссэн дээрх сорилтуудын үр дүнд Олон Улсын Валютын сан /ОУВС/-гийн 2022 оны 1 дүгээр сарын "Дэлхийн эдийн засгийн төлөв" тайланд дэлхийн эдийн засаг 2023 онд 3.8 хувиар өсөхөөр төсөөлж байсан бол 3 удаагийн үнэлгээгээр шинэчлэн 2022 оны 10 дугаар сард 2.7 хувь болгон бууруулжээ. Монгол Улсын эдийн засаг 2022 оны эхний хагас жилд 1.9 хувиар өссөн ба хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2.9 хувиар, 2023 онд 5.0 хувиар тус тус өсөх төсөөлөлтэй байна. Инфляцын түвшин 2022 оны 10 дугаар сард улсын хэмжээнд 14.6 хувьд хүрсэн ба үүний 7.6 хувьд импортын барааны үнийн өсөлт нөлөөлж байгаа юм.

---

[1] Тус хөтөлбөрийн хүрээнд АХБ хамтран санхүүжүүлэхээр тохиролцсон бөгөөд тус зээлийн хэлэлцээрийг 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр хийж, зээлийн гэрээнд 2022 оны 08 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан.

Геополитикийн хурцадмал байдал болон гадаад орчны нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2022 оны 3 дугаар улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 1,358.9 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 778.6 сая ам.доллароор өссөн үзүүлэлттэй байна. Гадаад валютын албан нөөц 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 2,935.1 сая ам.долларт хүрснээр оны эхэн үетэй харьцуулахад 1,010.0 сая ам.доллароор буурчээ.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2022 оны эхний 11 дугаар сард 14.4 их наяд төгрөг буюу 98.5 хувийн гүйцэтгэлтэй, нийт зарлага 15.5 их наяд төгрөг буюу 88.0 хувийн гүйцэтгэлтэй гарснаар төсвийн алдагдал 1,146.5 тэрбум төгрөг буюу 37.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, геополитикийн хурцадмал байдлаас шалтгаалсан Монгол Улсын эдийн засагт үүсээд буй инфляц, төлбөрийн тэнцлийн сөрөг нөлөөллийг бууруулахад АДБХОБ-наас олгох "Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр" нь бодлогын дэмжлэг үзүүлэх бөгөөд цаашид тус хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн хөрөнгө нь гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэхэд нэн шаардлагатай байна.

**В. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал**

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.3-т заасны дагуу Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2022 онд 70 хувь, 2023 онд 65 хувь, 2024 оноос эхлэн 60 хувиас хэтрэхгүй байхаар тус тус хуульчлагдсан.

Энэ хүрээнд 2022-2025 оны хооронд эдийн засаг харгалзан 2.9 хувь, 4.5 хувь, 5.1 хувь, 6.1 хувиар өсөж[2], Монгол Улсын 2022 оны батлагдсан төсөв, 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь 2022 онд 55.3 хувь, 2023 онд 53.2 хувь, 2024 онд 51.7 хувь болон 2025 онд 47.1 хувьтай тус тус тэнцэхээр тооцоологдсон. Ингэснээр эдгээр онуудад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахаар байна.

"Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ"-ний хүрээнд авч ашиглах 100.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн эх үүсвэр нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Засгийн газрын нэмэгдүүлэх өрийн дээд хэмжээнд нийцэж байна.

**Г. Хөтөлбөрийн шаардлага хангасан байдал**

"Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд АДБХОБ болон АХБ-наас 7 шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлага тавьсан. Монгол Улс энэхүү шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаад байгаад бөгөөд доорх хүснэгтээр дэлгэрэнгүйг харууллаа.

*Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал*

[2] Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг боловсруулахад ашигласан ДНБ-ний өсөлтийн төсөөлөл

| № | Шаардлага | Нийцэж буй байдал |
|---|---|---|
| 1 | Гадаад цочролын нөлөөллүүдэд өртсөн байх | КОВИД-19 цар тахлын нөлөөлөл, БНХАУ-ын хилийн хязгаарлалт болон ОХУ-Украины хооронд үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарах хүлээлттэй байгаа бөгөөд шатахуун болон импортын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан инфляцын дарамт нэмэгдэж, валютын нөөц огцом буураад байна. |
| 2 | Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн зардал | Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад эдийн засгийн хүндрэлийн үед хамгийн их нэрвэгдээд буй нийгмийн эмзэг бүлэгт бодлогын арга хэмжээнүүдийг чиглүүлэх шаардлагатай. Үүнд Хүүхдийн мөнгөн тэтгэмж, цалингийн дэмжлэг олгох, амьжиргааны түвшин доогуур бүсэд цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх зэрэг оршино. |
| 3 | Макро эдийн засгийн цочролын өмнөх оновчтой менежмент | Монгол Улсын бодит эдийн засгийн өсөлт 2017-2019 онд дунджаар 6.3 хувьтай тэнцэж, Засгийн газрын нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээ 81.4[3] хувь, төсвийн зарлага ДНБ-ний 30.7 хувьтай тэнцэж байсан. КОВИД-19 цар тахлын нөлөөллөөс эдгээр үзүүлэлтүүд муудсан бол 2022 оноос эхлэн төсвийн алдагдлыг бууруулах, өрийн бүтцийг сайжруулах зэрэг төсвийн оновчтой менежментийн бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн. |
| 4 | Бүтцийн шинэчлэл хийх | Монгол Улсын Засгийн газар дунд хугацааны бүтцийн шинэчлэлийн хүрээнд 2021 онд "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг батлуулж, эдийн засаг, төсвийн бодлогыг тус баримт бичгийн хүрээнд чиглүүлж байна. Түүнчлэн, санхүүгийн салбарын хувьд системийн ач холбогдол бүхий банкнууд хувьцаа эзэмшигчдийн бүтцийг төрөлжүүлэх, дүрмийн санг нэмэгдүүлэх зорилгоор зах зээлд хувьцаа гаргахаар төлөвлөж байна. |
| 5 | Өрийн тогтвортой байдал | Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу өнөөгийн үнэ цэнээр Монгол Улсын Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2024 он хүртэл буурч тогтворжих бөгөөд Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг баталснаар өрийн багц дахь зах зээлийн эрсдэл болон хүүгийн зардлыг бууруулах зорилтыг тавьсан. |
| 6 | ОУВС-тай хамтран ажиллах | ОУВС-гийн дүрмийн IV зүйлд заасны дагуу ОУВС нь 2021 оны 10 дугаар сарын 01-нээс 05-ны өдрүүдийн хооронд Монгол Улсын Засгийн газартай зөвлөлдөх уулзалтыг хийсэн. Үүний үр дүнд 2021 оны 11 дүгээр сарын 19-нд |

[3] Азийн дэд бүтцийн банк, Азийн хөгжлийн банкны тооцоолол

| | | |
|---|---|---|
| | | ОУВС-гийн ажилтнуудын ажлын тайланг Гүйцэтгэх зөвлөлд хэлэлцүүлсэн. IV-р зүйлийн ээлжит ажлын хэсгийн томилолтоос гадна хяналтын ажлын хэсгийг 2022 оны 04 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 03-ны өдрийн хооронд ОУВС, Засгийн газартай хамтран байгуулан ажилласан. |
| 7 | Хяналт шинжилгээ, үнэлгээ | Засгийн газар Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг ил тод мэдээлэх хяналт шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгохоор болсон. Үүнд, улирлын тайлангуудыг бэлтгэж, эдгээр тайлан, дүн шинжилгээнд ажлын хэсэг хяналт шалгалтын ажлыг гүйцэтгэнэ. |

** Эх сурвалж. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Азийн хөгжлийн банк*

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь АДБХОБ-наас 100.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг авч ашиглахаар төлөвлөж байна. Энэхүү зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 7 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа 3 жил байх ба хүүгийн түвшний хувьд хөвөгч суурь хүү болох Баталгаат овернайт санхүүжилтийн хүү[4] дээр 0.81 хувийн нэмэгдэлтэй байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд зээлдүүлэгч талын зүгээс Монгол Улсын нийгэм, эдийн засагт учраад буй сөрөг шокийн үед нийт хүн ам, тэр дундаа эмзэг, ядуу иргэдийн өртөмтгий байдлыг бууруулахад чиглэсэн Засгийн газраас нэгэнт авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг 2022 онд тууштай баримтлах чиглэлээр тоон шалгуур үзүүлэлтүүдийг хангах шаардлага тавьсан бөгөөд хөтөлбөрийн хамрах хүрээ, загвар болон хяналтын механизмын хүрээнд АХБ болон АДБХОБ-тай тохирсон тоон шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг улирал бүр тайлагнах юм.

Түүнчлэн, тус хөтөлбөрийн зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамжийн төслийг 11 дүгээр сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Улсын Их Хурлын байнгын хороодтой уг асуудлыг зөвшилцөхийг дэмжсэн. Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 11 дүгээр сарын 22-ны өдрийн, Төсөв болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороодын 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэж, зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурах асуудлыг дэмжсэн билээ. Ингэснээр 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Зээлийн хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулаад байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

[4] Secured overnight financing rate (SOFR)

Төсөл

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202.. оны ... дугаар сарын ...–ний өдөр Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улс, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк хооронд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан Зээлийн хэлэлцээр (Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Зээлийн дугаар L0688A

**МОНГОЛ УЛС**

**болон**

**АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК**

**хоорондын**

# ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

**(Мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээг дэмжих хөтөлбөр)**

**ОГНОО:2022 оны ...-р сарын ...-ны өдөр**

Монгол Улсын Сангийн яам
...ЫН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН
...ын үсэг /Signature/ ......М..........
20 22 оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот
... Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

## ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү хэлэлцээрийг МОНГОЛ УЛС (цаашид "Зээлдэгч" гэх) болон АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК (цаашид "Банк" гэх) хооронд 2022 оны ...-р сарын ...-ны өдөр байгуулав.

Өмнөтгөл:

A. Банк нь Зээлдэгчээс 2022 оны 08 сарын 17-ны өдөр 1-р хавсралтад туссан цочролуудын нөлөөг бууруулахад чиглэсэн Зээлдэгчийн Мөчлөг сөрсөн хөгжлийн зардлын хөтөлбөрийн зорилго, бодлого, үйл ажиллагаа, арга хэмжээг тусгасан хөгжлийн бодлогын асуудлаарх захидлыг хүлээн авсан.

B. Зээлдэгч нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Банкнаас зээл авах хүсэлт гаргасан;

C. Зээлдэгч нь Азийн хөгжлийн банк ("Хамтран санхүүжүүлэгч" гэх)-тай хамтран энэхүү Банкны зээлийн хэлэлцээрээс тусад нь хэлэлцээр ("Хамтран санхүүжүүлэх зээлийн хэлэлцээр" гэх)-ийг байгуулсан бөгөөд Хамтран санхүүжүүлэгч нь Зээлдэгчид нэг зуун сая (100,000,000) ам.доллартой тэнцэх зээл олгож, Хөтөлбөрийг хэсэгчлэн санхүүжүүлэхээр тохиролцсон;

D. Ийнхүү дээр дурдсан хэлэлцээр байгуулсныг харгалзан Банк нь энэхүү Зээлийн хэлэлцээрээр дор дурсан хугацаа, нөхцөлийн дагуу Зээлдэгчид зээл олгохыг зөвшөөрөв. .

Иймд, Банк болон Зээлдэгч дараах зүйлүүдийг харилцан тохиролцов:

### НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ; ТОДОРХОЙЛОЛТ

1.01. Ерөнхий нөхцөл (энэхүү Зээлийн хэлэлцээрийн Хавсралтад заасан) нь энэхүү Зээлийн хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

1.02. Энэхүү хэлэлцээрт том үсгээр бичсэн нэр томьёо нь тухайн хэсэгтээ агуулгын хувьд өөр утга илэрхийлээгүй бол энэ нэр томьёог Ерөнхий нөхцөлд заасантай ижил утгаар хэрэглэнэ.

### ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ЗЭЭЛ

2.01. Банк нь Зээлийн хэлэлцээрийн 1-р хавсралтад заасан хөтөлбөрийг санхүүжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор энэхүү Зээлийн хэлэлцээрт заaж тусгасан хугацаа, нөхцөлийг болзлын дагуу нэг зуун сая (100,000,00) ам.долларын зээл ("Зээл" гэх) олгохоор үүгээр тохиролцов.

2.02. Зээлдэгч нь уг Зээлийн хэлэлцээрийн 2-р хавсралтын 3 дахь хэсэгт заасны дагуу Зээлийн хөрөнгийг зарцуулна.

ОРЧУУЛГА ЗӨВ
Гарын үсэг /Signature/ ......
2022 оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот
OFFICIAL TRANSLATION

2.03. Зээлдэгчийн төлөх урьдчилж төлөх шимтгэл нь зээлийн нийт дүнгийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна. Зээлдэгч нь уг шимтгэлийг Зээл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор төлнө.

2.04. Зээлдэгчийн төлөх хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны шимтгэл нь жилд Зээлийн ашиглаагүй үлдэгдлийн нэг хувийн дөрөвний нэг (0.25%)-тэй тэнцүү байна.

2.05. Зээлдэгчийн хүү төлөх хугацаа тус бүрд төлөх хүүгийн хувь нь Жишиг хүү дээр Хувьсах хүүг нэмсэн байдлаар төлнө. Эсхүл хүүгийн өөрчлөлт хийсэн тохиолдолд өөрчилсөн хүүгийн хувиар тооцоолно.

2.06. Зээлийн хүүг жил бүрийн 06 дугаар сарын 15 болон 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд төлнө.

2.07. Зээлийн үндсэн дүнг энэхүү Зээлийн хэлэлцээрийн 3-р хавсралтад заасан эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.

## ГУРАВ ДУГААР ЗҮЙЛ. ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

3.01. Зээлдэгч нь Хөтөлбөрийн зорилтыг хангахаар тууштай ажиллахаа үгээр мэдэгдэж байна. Иймээс Зээлдэгч нь Сангийн яамаар дамжуулан, Ерөнхий нөхцөлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.02. Зээлийн хэлэлцээрийн 3.01 дэх заалтыг хязгаарлахгүйгээр, мөн Зээлдэгч ба Банк өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд энэхүү Зээлийн хэлэлцээрийн 2-р хавсралтад тусгасан заалтын дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## ДӨРӨВ ДҮГЭЭР ЗҮЙЛ. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

4.01. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Зээлийн хэлэлцээрийг байгуулсан өдрөөс хойш 90 хоног дахь өдөр байна.

## ТАВ ДУГААР ЗҮЙЛ. ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ; ХАЯГ

5.01. Ерөнхий нөхцөлийн 10.02 дахь заалтын дагуу Сангийн сайд нь Зээлдэгчийн төлөөлөгч байна.

5.02. Ерөнхий нөхцөлийн 10.01 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах хаягийг ашиглана:

Зээлдэгч:

Сангийн яам, Засгийн газрын 2-р байр,
С.Данзангийн гудамж 5/1,
Улаанбаатар хот - 15160, Монгол Улс
Факсын дугаар: +976-11- 320-247

5.03. Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк:

OFFICIAL TRANSLATION

Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны төв байр, А цамхаг,
Азийн санхүүгийн төв № 1 Тяньчений зүүн зам,
Чаоян дүүрэг, Бээжин хот - 100101, БНХАУ
Факсын дугаар: +86-10-8358-0002

Дээр заасан он, сар өдөр ДЭЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ гарын үсэг зурав

**МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**

________________________

**[Эрх бүхий албан тушаалтан]**

**Нэр :________________________**

**Албан тушаал :_______________**

**АЗИЙН ДЭД БҮТЦИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКИЙГ ТӨЛӨӨЛЖ**

________________________

**[Эрх бүхий албан тушаалтан]**

**Нэр :________________________**

**Албан тушаал :_______________**

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН

Гарын үсэг /Signature/ ....................

20 .. оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот

Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

**1 дүгээр хавсралт**

**Хөтөлбөрийн тодорхойлолт**

Хөтөлбөрийн гол зорилго нь хүн амын, ялангуяа эмзэг бүлгийн нийгэм - эдийн засгийн цочролуудын даван туулах чадавхыг нэмэгдүүлэх юм. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнд (а) өрхийн бэлэн мөнгөний эх үүсвэрийг богино хугацаанд шууд нэмэгдүүлэх; (б) эмзэг бүлгүүдэд, охид, эмэгтэйчүүдэд учирч буй нийгэм -эдийн засгийн нөлөөллийг багасгах; (в) инфляцыг бууруулж хүнсний аюулгүй байдлыг хангах. Бодлогын асуудлаарх захидалд Хөтөлбөрийн тухай дэлгэрэнгүй тусгасан болно.

Монгол Улсын Сангийн яам
ЭХ БИЧГЭЭС ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature/ ........................
20 22 оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот
Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

## 2-р хавсралт

## Хөтөлбөр

### 1-р хэсэг. <u>Хэрэгжүүлэх зохицуулалт</u>

### А. Холбогдох төрийн байгууллагын зохион байгуулалт

1. Зээлдэгч нь Сангийн яамаар дамжуулан Хөтөлбөрийн хэрэгжилт болон хяналт, тайлагналтыг хариуцна.

### Б. Бодлогын асуудлаарх яриа хэлэлцээ

1. Зээлдэгч Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад тулгарсан аливаа асуудал, хязгаарлалтын талаар Банкинд нэн даруй мэдэгдэх, мөн эдгээр асуудлыг шийдвэрлэх, зохицуулахад чиглэсэн зохих арга хэмжээг авахын тулд АХБ-тай идэвхтэй хамтран ажиллана.

2. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлж болох олон талт болон хоёр талт тусламжийн бусад агентлагуудтай бодлогын өөрчлөлт, хэлэлцүүлгийн талаар Банкинд мэдээлж байх бөгөөд Банкинд аливаа бодлогын яриа хэлэлцээрийн талаар санал өгөх боломжийг олгоно. Зээлдэгч бодлогын яриа хэлцлийг эцэслэн боловсруулж хэрэгжүүлэхийн өмнө Банкны саналыг харгалзан үзнэ.

### В. Монголын талын санхүүжүүлэлтийг ашиглах

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийн зорилгод нийцсэн тодорхой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг санхүүжүүлэхэд Монголын талын санхүүжүүлэлтийн хөрөнгийг зарцуулна.

### Г. Хориглосон үйл ажиллагаа

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн боловсон хүчин болон бусад төлөөлөгчдийг Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ ёс зүйн дээд хэм хэмжээг баримтлахыг шаардана. Үүний тулд Зээлдэгч нь (а) хүн болгон нь ээлтэй холбоотой аливаа хориотой үйл ажиллагаа явуулахгүй байх; (б) Хориглосон үйлдлийн талаарх бодлогын дагуу Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг баталгаажуулна.

### Д. Байгаль орчны болон нийгмийн шаардлага

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хамтран санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банкны "Хамгааллын бодлого"-ын дагуу хэрэгжүүлнэ.

2. Дээрх 1 дэх заалтыг хязгаарлахгүйгээр Хамтран санхүүжүүлэгчийн "Хамгааллын бодлого"-ын дагаж мөрдөж буй тухай гомдол Банкинд ирсэн

ЕСНЫ ОРЧУУЛГА МӨН
Signature/
20 оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот
of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

тохиолдолд Банк уг гомдлыг Хамтран санхүүжүүлэгчид шалгуулахаар шилжүүлж, тэр нь өөрийн хариуцлагын шат дамжлагаар мөрдөн шалгана гэдгийг Зээлдэгч хүлээн зөвшөөрч байна.

**2-р хэсэг. <u>Хяналт, үнэлэлт болон тайлан</u>**

**А. Хөтөлбөрийн хяналт, тайлан**

1. Зээлдэгч нь (а) үндсэн оролцогч талуудтай бодлогын яриа хэлэлцээ хийх, хэлэлцээний үр дүнг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой платформыг Мөчлөг сөрсөн санхүүжилтийн зардлын хөтөлбөрийн хүрээнд багтаан боловсруулна; ба (б) үүнийг хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгарч байгаа бол хариу арга хэмжээ авнө.
2. Зээлдэгч (а) өөрийн хяналт, шалгалтын механизмын дагуу хяналт тавьж, үнэлж, улирал тутам тайланг Банкинд гаргаж өгнө; (б) хяналт, шалгалтыг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв болон хүний нөөцийг бүрдүүлнэ.

**Б. Санхүүгийн тайлан, аудит**

1. . Зээлдэгч нь Банкны хүлээн зөвшөөрөх хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу Хадгаламжийн данстай байж, тусад нь данс, бүртгэлийг хөтөлнө.
2. Банкны хүсэлтээр Зээлдэгч Хадгаламжийн дансны санхүүгийн тайланд аудит хийлгэх ба аудиторын хараат бус байдал, мэргэшил, туршлага, ажлын хүрээ зэрэг нь Банкаар хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын стандартад нийцсэн эсвэл Банкаар зөвшөөрөгдсөн дотоод стандартад нийцсэн байх. Бэлтгэл ажил хангагдсаны дараа нэн даруй, гэхдээ Банк хүсэлт гаргасан өдрөөс хойш 6 сарын дотор аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн хуулбар болон санхүүгийн тайлангийн талаарх аудиторуудын дүгнэлтийг англи хэл дээр Банкинд ирүүлнэ.

**3-р хэсэг. <u>Зээлийн ашиглалт</u>**

**А. Ерөнхий нөхцөл**

1. Зээлдэгч нь Ерөнхий нөхцөлийн II дугаар зүйл, энэ заалт болон Банкнаас Зээлдэгчид мэдэгдэх нэмэлт зааварчилгааны дагуу зээлийн хөрөнгөө татан авч болно.
2. *Зээлийн хуваарилалт.* Зээлийг нэг удаагийн санхүүжилтээр хуваарилах бөгөөд Зээлдэгч Зээлийн данснаас мөнгө гарган авах боломжтой. Энэ зорилгоор Зээлийн дүнгийн хуваарилалтыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature/ ......
20 18 оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот
Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

| Ашиглалт | Ашиглалтын дүн (ам.доллароор) |
|---|---|
| Ашиглалт | 100,000,000 |
| НИЙТ ДҮН | 100,000,000 |

**Б. Ашиглалтын нөхцөл, хугацаа**

1. *Ашиглалтын нөхцөл.* Энэ хэсгийн А заалтад өөрөөр заасан ч Банк урьдчилж төлөх шимтгэлийг бүрэн хүлээн авч, Хамтарсан санхүүжилтийн гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл Зээлийн данснаас мөнгө гаргахгүй.
2. *Зээлийн мөнгөн дүнгийн хадгаламж.* Банк өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд:

   (а) Зээлийн данснаас гарсан бүх мөнгийг Банк Зээлдэгчийн заасан дансанд байршуулна ("Хадгаламжийн данс");

   (б) Зээлдэгч нь Зээлийн мөнгөн дүнг Хадгаламжийн дансанд оруулах бүрд түүнтэй тэнцэх хэмжээний мөнгийг Банкны хүлээн зөвшөөрөхүйц байдлаар Зээлдэгчийн төсвийн удирдлагын тогтолцоонд бүртгэхийг баталгаажуулна.

3. *Үл зөвшөөрөх жагсаалт.* Энэхүү 2-р хавсралтын 1 дэх дэд хавсралтад заасан аливаа зүйлийг санхүүжүүлэхэд Зээлийн орлогыг татан авахгүй.
4. *Ашиглалтын хугацаа.* Хаалтын хугацаа нь 2023 оны 6-р сарын 30-ны өдөр байна.

**4-р хэсэг.** **<u>Бусад</u>**

1. Зээлдэгч нь Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Зээлийн орлогоос гадна шаардагдах хөрөнгө, барилга байгууламж, үйлчилгээ болон бусад эх үүсвэрийг шаардлагатай бол нэн даруй гаргана.

Монгол Улсын Сангийн яам
АЛБАН ЁСНЫ ОРЧУУЛГА МӨН
Гарын үсэг /Signature/ ...
20 23 оны ... сарын ... өдөр
Улаанбаатар хот
Ministry of Finance of Mongolia
OFFICIAL TRANSLATION

<u>2-р хавсралтын 1 дэх хавсралт</u>

**<u>Үл зөвшөөрөх жагсаалт</u>**

Дараах зүйлсийн санхүүжилтэд Зээлийг зарцуулахгүй:

